



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 8771

Улаанбаатар хот

**Дүүргийн “Жендэрийн эрх тэгш байдлыг
хангах дэд салбар хороо”-ны бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 227 дугаар тогтоолоор баталсан Жендэрийн үндэсний хорооны дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар Жендэрийн үндэсний хороо, нийслэл, дүүргийн баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд дүүргийн салбарын төлөөллүүдийн оролцоог хангах, үйл ажиллагааг эрчимжүүлэх чиг үүрэг бүхий дүүргийн “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд салбар хороо”-г шинэчлэн байгуулсугай.

2. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд салбар хороо”-ны шинэчилсэн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Салбар дэд хороог арга зүйгээр ханган, жендэрийн эрх тэгш байдлын чиглэлээр нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион байгуулж, холбогдох тайлан, мэдээг цаг хугацаанд нь хүргэн ажиллахыг дүүргийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд салбар хороо (Х.Цогцэцэг)-нд үүрэг болгосугай.

4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд салбар хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/114 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 01 дугаар сарын 01 -ны өдрийн
877... дугаар захирамжийн хавсралт

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САЛБАР
ХОРООНЫ ШИНЭЧИЛСЭН БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга Засаг даргын орлогч

Гишүүд: Засаг даргын Тамгын газрын дарга
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Цэргийн штабын дарга
1 дүгээр хорооны Засаг дарга
2 дугаар хорооны Засаг дарга
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн эрх зүй, хяналт
шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтсийн дарга
Боловсролын хэлтсийн дарга
Эрүүл мэндийн төвийн дарга
Цагдаагийн хэлтсийн дарга
Онцгой байдлын хэлтсийн дарга
Биеийн тамир, спорт хорооны дарга
Соёлын ордоны захирал
Нийслэлийн ерөнхий боловсролын 91 дүгээр сургуулийн
захирал
Нийслэлийн ерөнхий боловсролын 94 дүгээр сургуулийн
захирал
Насан туршийн суралцахуйн төвийн дарга
Дүүргийн статистик хариуцсан мэргэжилтэн
Дүүргийн эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга
Дүүргийн залуучуудын холбооны дарга
Дүүргийн ахмадын хорооны дарга
Дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны дарга
Дүүргийн хэвлэл мэдээллийн ажилтан

Нарийн бичгийн дарга:

Дүүргийн Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн